

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 08 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох заалтуудын 2023 оны 07 дугаар сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 зорилтын хүрээнд 3 арга хэмжээний хэрэгжилтийг хамруулсан болно. Үүнд:

1.“Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ” арга хэмжээний хүрээнд:

“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) систем дэх визийн зөвшөөрлийн хүсэлт илгээх болон хүлээн авах хэсгийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж, визийн зөвшөөрөл, визийн хугацаа сунгах, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны хүсэлтийн төлбөрийн модуль, хүсэлт хуваарилах модуль, зөрчил санал шийдвэрлэх хэсгийг хөгжүүлж дуусган, Production Server 28 ширхгийг бэлтгэлээ. Хөгжүүлэлтэд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.

2.“Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтын хүрээнд:

Авлигатай тэмцэх газраас 2 жил тутам гэрээгээр гүйцэтгүүлдэг төрийн байгууллагын шударга байдлыг үнэлэх судалгааны хүрээнд “Эс Ай Си Эй” компанийн судлаачтай хамтран ажиллаж, төрийн байгууллагын шударга байдлын талаар бодлогод оролцогч, шинжээчид болох холбогдох байгууллагын 20 албан тушаалтны судалгааг нэгтгэж ажиллав. Түүнчлэн байгууллагад ажиллаж байгаа 50 төрийн албан хаагч, үйлчилгээний зааланд биечлэн үйлчлүүлж байгаа иргэд 07 дугаар сарын 25-аас 28-ны өдрүүдэд тусгай асуумжийн дагуу уг судалгаанд хамрагдлаа.

3.“Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана” зорилтод тусгагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана” арга хэмжээний хүрээнд:

Байгууллагын даргын 06 дугаар сарын 08-ны өдрийн А/190 дүгээр тушаалаар байгуулсан “Үнэлгээний баг”-аас албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг бодитой үнэлэх, ажлын гүйцэтгэл үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхэд баримтлах зөвлөмж”-ийг боловсруулж, 07 дугаар сарын 05-ны өдрийн 02/1132 дугаар албан бичгээр зохион байгуулалтын нэгжийн дарга нарт танилцуулсан.

Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчсөн үндэслэлээр байгууллагын даргын 06 дугаар сарын 30-ны өдрийн Б/188, Б/189 дүгээр тушаалаар 2 албан хаагчид албан тушаалын цалинг 3 сарын хугацаатай 20 хувиар бууруулах, 07 дугаар сарын 28-ны өдрийн Б/204 дүгээр тушаалаар 1 албан хаагчид нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах сахилгын шийтгэл тус тус ногдуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилт 07 дугаар сард 73.3 хувь буюу 3.7 оноотой дүгнэгдлээ.

Тус үйл ажиллагааны хөтөлбөрийн “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ” арга хэмжээ 50 хувьтай, “Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно” арга хэмжээ 100 хувьтай, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана” арга хэмжээ 70 хувьтай үнэлэгдсэн.

Иймд “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана” арга хэмжээний хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчлийг бууруулахын тулд тогтмол сургалт, сурталчилгаа явуулах, “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ” арга хэмжээний хүрээнд “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн үйл ажиллагаа жилийн эцэст хэвийн явагддаг болсон байх зорилт тавьсан тул уг арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗАР